**МОНГОЛ УЛСЫН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН**
**ТУШААЛ**

2018 оны 01 сарын 25 өдөр Дугаар А/18 Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 22 дахь зүйлийн 22.1.3, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 243 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний 5 дахь хөтөлбөр" -ийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. "Эрүүл мэндийн салбарт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах үйл ажиллагааны жишиг төлөвлөгөө 2018-2020"-ыг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

3. Төлөвлөгөөний хэрэгжилттэй холбоотой зардлыг жил бүрийн төсөвтөө тусгахыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх тайланг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд ирүүлэхийг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

5. Төлөвлөгөөний хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх болон хэрэгжилтийн талаарх нэгдсэн тайланг жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны дотор Эрүүл мэндийн яаманд ирүүлэхийг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Б.Цогтбаатар/-д үүрэг болгосугай.

САЙД Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 01 сарын 25-ны өдрийн
А/18 дугаар тушаалын хавсралт

# ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ АЖИЛЛАГСДЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙГ САЙЖРУУЛАХ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИШИГ ТӨЛӨВЛӨГӨӨ 2018-2020

| | Зорилго | Эрүүл мэндийн салбарт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, ажлын байрны эрүүл ахуйг сайжруулах | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **Үйл ажиллагааны чиглэл 1** | **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчинтой холбоотой стандарт, хууль эрх зүйн бодлогын хэрэгжилтийг хангах чиглэлээр** | | | | |
| № | Үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага | Хэрэгжих хугацаа |
| | Эрүүл мэндийн ажилтнуудын ажлын ачааллыг харгалзан хөдөлмөрийн норм, нормативыг шинэчилж, батлуулах | Сайдын тушаал | Шинээр батлагдсан хөдөлмөрийн норм, норматив | ЭМЯ, НЭМҮТ | МЭМАҮЭХ | 2018-2019 |
| | Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг Хөдөлмөрийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/223 дугаар тушаалын дагуу холбогдох байгууллагатай хамтран үнэлгээ хийлгэж хэвших | Үнэлгээний зөвлөмж | Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэдэг байгууллагын эзлэх хувь | Аймаг, Нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллага | НЭМҮТ, ХАБЭМТ, холбогдох мэргэжлийн байгууллага | Жил бүр |
| | Ажлын байранд тавигдах ХАБЭА-н дотоодын болон хөндлөнгийн хяналтын тогтолцоог бүрдүүлж, үйл ажиллагааг тогтмолжуулах | Дотоод журам | ХАБЭА-н дотоодын болон хөндлөнгийн хяналтын тогтолцоотой байгууллагын эзлэх хувь | Аймаг, Нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллага | ЭМЯ, НЭМҮТ | Жил бүр |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | ХАБЭА-н тухай хуулийн 26.2-т заасан хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах, эрүүл ахуйн орчинг сайжруулах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд тухайн жилийн батлагдсан төсвийн 0,5-аас доошгүй хувийг зарцуулах арга хэмжээ авч, үр дүнг тооцох | Батлагдсан төсөв | Төсвийн 0.5-аас доошгүй хувийг зарцуулах арга хэмжээ авч, үр дүнг тооцон ажиллаж буй байгууллагын эзлэх хувь | Аймаг, Нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллага | ЭМЯ, НЭМҮТ | Жил бүр |
| 5 | Хууль тогтоомжид заасны дагуу ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтанг ажиллуулах, хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгож, хариуцах чиг үүргийг тодорхой болгох | Батлагдсан төсөв | ХАБЭА-н асуудал хариуцсан орон тооны ажилтантай байгууллагын эзлэх хувь | Аймаг нийслэлийн ЭМГ,<br><br>Эрүүл мэндийн байгууллага | ЭМБ, эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн хороод | 2018-2019 |
| 6 | Эрсдэлийн түвшин их ажлын байранд ажиллаж байгаа ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд тухайн ажилтны 36 ба түүнээс дээш сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээгээр заавал даатгуулах ажлыг зохион байгуулах | Даатгалын байгууллагатай байгуулсан гэрээ | Даатгалд хамрагдсан ажилтны тоо | Эрүүл мэндийн байгууллага | ЭМЯ | 2018-2019 |
| 7 | ХАБЭА-н сургалтын хэрэгцээг жил бүр тодорхойлох, төлөвлөх, сургалт зохион байгуулах | Сургалтын хөтөлбөр, | Сургалтад оролцогчдын тоо | Эрүүл мэндийн байгууллага | ЭМЯ, НЭМҮТ, ХАБЭМТ, МЭМАҮЭХ | Жил бүр |
| 8 | “Ажлын ачааллын үнэлгээ”–г хагас жилд нэг удаа хийж, нотолгоонд тулгуурлан ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ажил | Үйл ажиллагааны тайлан | Ажлын ачааллын үнэлгээ хийлгэж, арга хэмжээ авсан байгууллагын эзлэх хувь | Эрүүл мэндийн байгууллага | НЭМҮТ, Эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн хороод | Хагас жил тутам |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | үүргийн хувиарлалтыг оновчтой болгох, давхардлыг арилгах арга хэмжээ авах | | | | | |
| ) | Ажлын байранд “5А ЗАРЧИМ”-ыг хэвшүүлэх | Үйл ажиллагааны тайлан | “5А ЗАРЧИМ”-ыг хэвшүүлсэн байгууллагын эзлэх хувь | Эрүүл мэндийн байгууллага | НЭМҮТ | Тогтмол |
| | **Үйл ажиллагааны чиглэл 2.** | **Бие махбодь, сэтгэл зүйн таатай нөхцөлд хөдөлмөрлөх аюулгүй, эрүүл ажлын орчинг бий болгох чиглэлээр** | | | | |
| 0 | “Эрүүл ажлын байр” санаачлагыг өргөжүүлэх, ажлын байранд эрүүл, аюулгүй байдлыг дэмжих соёлыг төлөвшүүлэх | Үйл ажиллагааны тайлан | “Эрүүл ажлын байр” санаачлагыг тогтмол хэрэгжүүлдэг байгууллагын эзлэх хувь | Аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн байгууллага | НЭМҮТ, ХАБЭМТ | Тогтмол |
| 1 | Ажлын байранд стрессээс сэргийлэх, стресс менежментийн талаар сургалт зохион байгуулах | Сургалтын хөтөлбөр, тайлан | Сургалтад оролцогчдын тоо | Аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн байгууллага | НЭМҮТ, СЭМҮТ | Тогтмол |
| 2 | Алжаал тайлах, амрах өрөөг тохижуулж, байнгын ашиглах боломж нөхцөлөөр хангах | Шинээр тохижуулсан алжаал тайлах өрөө | Алжаал тайлах, амрах өрөөг тогтмол ажиллуулдаг байгууллагын тоо | Эрүүл мэндийн байгууллага | НЭМҮТ, ХАБЭМТ | 2018 |
| 3 | Эрүүл мэндийн салбарт “MNSOSHAS18001:2012 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо-шаардлага” стандартыг нэвтрүүлж, жишиг эрүүл мэндийн байгууллагуудыг бий болгох | Үйл ажиллагааны тайлан | Стандарт нэвтрүүлж, стандартын шаардлага хангасан эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь | Эрүүл мэндийн байгууллага | НЭМҮТ, ХАБЭМТ, МЭМАҮЭХ | 2018-2020 |
| 4 | Эрүүл мэндийн ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд жил бүр | Үзлэгийн мэдээ, бүртгэлжилт, дархлаажуулалтын | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан | Эрүүл мэндийн байгууллага | ХАБЭМТ, ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын | Жил бүр |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тогтмол хамруулах, дархлаажуулах, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах | хамруулалт | ажилтны тоо, дархлаажуулалтын хамруулсан ажилтны тоо | | алба | |
| 5 | С вирус илэрсэн ажилтнуудыг эмчлэн, эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах | Үзлэгийн мэдээ, бүртгэлжилт | Эмчлэгдэн эрүүлжигдсэн эрүүл мэндийн ажилтны тоо | Эрүүл мэндийн байгууллага | ХАБЭМТ, ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын алба | Жил бүр |
| 6 | Эрүүл мэндийн ажилтныг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс үүдэлтэй халдвараас сэргийлэх сургалт зохион байгуулах | Сургалтын хөтөлбөр, тайлан | Сургалтад оролцогчдын тоо | Эрүүл мэндийн байгууллага | ХӨСҮТ | Тогтмол |
| 7 | Хөдөлмөрийн чадвар алдалтын үед ажлын байрыг сэлгэн ажиллуулахдаа дадлагажуулах, сургах, нөхөн сэргээх, нийгэмд дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх | Тайлан | Дэмжлэг үзүүлсэн болон авсан арга хэмжээний тайлан | Эрүүл мэндийн байгууллага | НЭМҮТ, ХАБЭМТ | Жил бүр |
| 8 | Ажлын байртай холбоотой эрсдлийг бууруулах байгууллагын эрсдэлийн удирдлагын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | Эрсдлийн удирдлагын батлагдсан хөтөлбөр | Эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй байгууллагын тоо | Эрүүл мэндийн байгууллага | НЭМҮТ, ХАБЭМТ | Тогтмол |
| 9 | Ажилтан бүрт “АЮУЛГҮЙ, ЗӨВ АЖИЛЛАХ ЗАН ҮЙЛ-ийг төлөвшүүлэх зорилгоор тасралтгүй сургалт, сурталчилгааг асуудал хариуцсан байгууллагатай хамтран зохион байгуулах | Сургалтын хөтөлбөр, тайлан | Сургалтад хамрагдсан ажилтны тоо | Эрүүл мэндийн байгууллага | НЭМҮТ, ХАБЭМТ, ХӨСҮТ, холбогдох мэргэжлийн байгууллага | Жил бүр |
| 10 | Олон улсын Хөдөлмөрийн байгууллагаас санаачилсан жил бүрийн 4 дүгээр сарын 28-нд зохион байгуулдаг “Хөдөлмөрийн | Үйл ажиллагааны тайлан | Батлагдсан удирдамж, үйл ажиллагааны тайлан, хамрагдсан ЭМБ-ын тоо | Эрүүл мэндийн байгууллага | НЭМҮТ, ХАБЭМТ, холбогдох мэргэжлийн байгууллага | Жил бүр |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | аюулгүй байдал. Эрүүл ахуйн дэлхийн өдөр-ийг тэмдэглэх | | | | | |
| | **Үйл ажиллагааны чиглэл 3** | **Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тохиолдлыг бууруулах чиглэлээр** | | | | |
| 21. | Халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээрх тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр дүнг тооцож ажиллах | Үйл ажиллагааны тайлан | “Эрүүл ажлын байр” санаачлагыг тогтмол хэрэгжүүлдэг байгууллагын эзлэх хувь | Эрүүл мэндийн байгууллага | ХӨСҮТ | Тухай бүр |
| 22. | Эргономикийн эрсдэлт хүчин зүйлсийн өртөлтийг бууруулах арга хэмжээ авах, тэдгээрийг бууруулах сургалт зохион байгуулах | Шинээр тохижуулсан алжаал тайлах өрөө | Алжаал тайлах, амрах өрөөг тогтмол ажиллуулдаг байгууллагын эзлэх хувь | Эрүүл мэндийн байгууллага | НЭМҮТ, холбогдох мэргэжлийн байгууллага | Тогтмол |
| 23. | Үйлдвэрлэлийн горим, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмыг зөрчихгүй байхыг сануулсан эмдэг, тэмдэглэгээ, анхааруулга, сэрэмжлүүлэг хэрэглэж хэвших | Байршуулсан анхааруулах тэмдэг | Арга хэмжээний тайлан | Эрүүл мэндийн байгууллага | НЭМҮТ, ХАБЭМТ, холбогдох мэргэжлийн байгууллага | Тогтмол |
| 24. | Эрсдэл ихтэй ажлын байрны хяналтын хуудсыг хөтөлж, баталгаажуулан үр дүнг тооцох | Хяналтын хуудас | Хяналтын хуудсыг мөрдөж, үр дүнг тооцсон тайлан | Эрүүл мэндийн байгууллага | НЭМҮТ, ХАБЭМТ, холбогдох мэргэжлийн байгууллага | Тогтмол |
| 25. | Ажилтны нийтлэг гаргадаг алдаа, зөрчил, түүний у лмаас гарсан осол, өвчлөлийн үр дагаврыг харуулсан гарын авлага, мэдээлэл, сургалт, сурталчилгааны материалыг боловсруулж, сурталчлах | Гарын авлага, сургалтын материал | Боловсруулсан гарын авлага, МСС-ны материалын төрөл, тоо | Эрүүл мэндийн байгууллага | Холбогдох мэргэжлийн байгууллага | Тогтмол |
| 26. | Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, мэдээллийг сайжруулах, мэдээллийн сан байгуулах | Мэдээллийн сан | Мэдээллийн сантай байгууллагын эзлэх хувь | Аймаг нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллага | Холбогдох мэргэжлийн байгууллага | Тогтмол |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 27. | Хувийн хамгаалах хэрэгсэл болон ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр тодорхой гарфик гарган хангах үйл ажиллагааг зохион байгуулах | График, тайлан | Хувийн хамгаалах хэрэгслээр хангагдсан тоо, төрөл | Аймаг нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллага | Холбогдох мэргэжлийн байгууллага | Тухай бүр |
| 28. | Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагад ажиллагчдын халдварт өвчинд өртөх өртөлт, МШӨ-ний судалгаа хийх | Судалгааний тайлан | Арга хэмжээний тайлан | Эрүүл мэндийн байгууллага | ХӨСҮТ | Жил бүр |